## ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН /ЭХНИЙ ХАГАС ЖИЛЭЭР/

***2024 оны 05 сарын 28***

УБЕГазраас албан бичгээр ирүүлсэн Даргын зөвлөлийн хурал, шуурхай хуралдаанаас ирүүлсэн 10 удаагийн үүрэг даалгавар, чиглэлийн хүрээнд холбогдох ажлуудыг зохион байгуулж тайлан мэдээг илтгэх хуудсаар хугацаанд нь өгч ажиллалаа.

***<u>1-рт. Иргэний бүртгэлийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд:</u>***

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн Газраас ирсэн хугацаатай үүрэг даавгавар 9 , МУИХурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 11 нийт 20 албан бичгийн хүрээнд үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган биелэлтийг хугацаанд нь ИУБГазарт илтгэх хуудсаар хүргүүлэн ажиллалаа.

Эхний хагас жилд 4512 иргэнд иргэний гэр бүлийн бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. Тайлант хугацаанд ИГББүртгэлийн сар бүрийн тоон мэдээний нэгтгэлийг 5, инфографик мэдээ 5 удаа гаргаж өгсөн. Иргэний бүртгэлийн санд мэдээлэл тусгагдаагүй, мэдээлэл засуулах хүсэлтэй, регистрийн дугаар буруу олгогдсон зэрэг 14 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа. 2024 оны 05 сарын байдлаар 834 иргэн биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамрагдсан бөгөөд шинээр 323 иргэн, 25, 45 насны сунгалтаар 489 иргэн, дахин бүртгэлээр 22 иргэн бүртгэлд хамрагдсан байна. Иргэний улсын бүртгэлийн газраас 16 удаагийн ээлжээр 943 иргэний үнэмлэх хүлээн авсан үүнээс 16 насанд хүрч шинээр иргэний үнэмлэх захиалсан 320, хаяж үрэгдүүлсэн болон дахин захиалсан 142, 25 болон 45 насны сунгалтаар 481 иргэний үнэмлэх хэвлэгдэн ирснийг сумдын улсын бүртгэгчдэд хүргүүллээ.
Аймгийн хэмжээнд нийт 32044 иргэнд тоон гарын үсэг олгохоос 21162 иргэн буюу 66 хувьд олгоод байна. 2024 оны 5 сарын байдлаар нийт 1814 иргэнд тоон гарын үсэг олгосон. Тоон гарын үсгийг 731 иргэнд иргэний үнэмлэхийн чипэнд, 1083 иргэнд гар утасны gsign апплекейшнаар дамжуулан олголоо. Тоон гарын үсгийг нийт 549 иргэн киоск машинаар авсан байна.

Бүртгэлийн үйлчилгээний Киоск эхний хагас жилийн байдлаар 248 лавлагаа гарсан байна. Сайнцагаан сумын бүртгэгчийн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа төлбөрийн пос машинаар он гарсаар 540 иргэн бүртгэлийн үйлчилгээний төлбөр тооцоог хийсэн байна. Төлбөр тооцооны системийг бүртгэлийн үйлчилгээнд нэвтрүүлсэн нь үйлчилгээний шат дамжлага буурсан, цаг хугацаа зардал хэмнэсэн үйлчилгээ болж чадлаа. Тайлант хугацаанд төрийн үйлчилгээний ‘’Хурдан систем’’-ээс гэрлэсний бүртгэлгүй 44 лавлагаа, гэрлэлтийн бүртгэлийн 122, иргэний үнэмлэхийн лавлагаа 972, төрсний гэрчилгээний лавлагаа 414, оршин суугаа хаягийн лавлагаа 591 нийт 2143 иргэн бүртгэлийн лавлагаа мэдээлэл авч үйлчлүүлсэн байна. 2024 оны эхний хагас жилийн байдлаар бүртгэлийн үйлчилгээний нэг цэгийн танхимд байрлах D83 төхөөрөмжөөр 2914, Дэрэн сумын D152 төхөөрөмжөөр 0, Эрдэнэдалай сумын D179 төхөөрөмжөөр 264 нийт 3178 бүртгэлийн үйлчилгээний төлбөрийг Гэрэгэ системээр тушаасан тухай мэдээллийг гэрэгэ систем компаны орон нутаг хариуцсан менежер М.Билгүүндалайтай холбогдож мэдээлэл солилцон ажиллаж байна . Дэрэн сумын гэрэгэ киоск төхөөрөмжийн үйлчилгээг сайжруулахад анхаарч өгөх талаар санал хэллээ.

Тайлант хугацаанд төрөлтийн бүртгэлд 286 хүүхэд, гэрлэлтийн бүртгэл 44, үрчлэлт 4, гэрлэлт цуцлалтын бүртгэл 16, эцэг тогтоолтын бүртгэл 12, ОНӨ бүртгэл 13, нас барсны бүртгэлд 111 нийт иргэний гэр бүлийн бүртгэлийн 486 бүртгэл, 718 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд, үндэсний энгийн гадаад паспорт 354, иргэний үнэмлэх 943 иргэнд олгож нийт 2501 бүртгэл хөтлөн иргэний бүртгэлийн санд мэдээллийг баталгаажуулсан байна. Эрүүл мэндийн яамны мэдээллийн сангаас 286 хүүхдийн регистрийн дугаарыг унагаж төрсний бүртгэлд бүртгэсэн бөгөөд 148 эрэгтэй, 138 эмэгтэй хүүхэд төрсөн байна. Төрсөн эхчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-19 насны 19, 20-24 насны 59, 25-29 насны 84, 30-34 насны 44, 40-44 насны 11 эмэгтэй төрсөн байна. Батлуулсан гэр бүлтэй 117 эмэгтэй, батлуулаагүй гэр бүлтэй 134 эмэгтэй төрж бүртгэгдсэн байна. Бүрэн дунд боловсролтой 113, дээд боловсролтой 94 эх төрсөн нь нийт төрсөн эхчүүдийн 72,3 хувь

байна. Нийт төрсөн хүүхдийн 59,8 хувь буюу 171 хүүхэд Сайнцагаан суманд төрсний бүртгэлд хамрагдсан байна. Нийт 1322 лавлагаа хэвлэсэн бөгөөд хууль хяналтын байгууллагын хүсэлтээр 94 лавлагаа хэвлэж олгосноос цагдаагийн байгууллагын хүсэлтээр 20, Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр 25, Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн хүсэлтээр 27, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хүсэлтээр 22 лавлагааг тус тус олгосон. Албан хэрэгцээнд 402 лавлагааг улсын бүртгэгчид хэвлэж, иргэний хүсэлтээр 826 лавлагаа олгосон байна. Эхний хагас жилд 718 иргэн шилжин ирсний бүртгэлд хамрагдсанаас гадны аймаг хотоос 342 иргэн бүртгэгдсэн. Гадны аймаг хотоос шилжин ирсэн 16-аас дээш насны 213 иргэн, 16-аас доош насны 129 иргэн, аймаг доторх шилжилт хөдөлгөөн сумаас суманд 16-аас дээш насны 92 иргэн, 16-аас доош насны 81 иргэн, багаас багт шилжсэн 16-аас дээш насны 112 иргэн, 16-аас доош насны 91 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэсэн байна. Улаанбаатар хотоос 262 иргэн, Говьсүмбэр аймгаас 23 иргэн шилжин ирсэн нь гадны аймаг хотоос шилжин ирсэн иргэдийн 83,3 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд 560 иргэн өөр аймаг хотод шилжин явснаас 16- аас доош насны 162, 16-аас дээш насны 398 иргэн өөр аймаг хотод шилжин явсан хөдөлгөөний бүртгэлд хамрагдсан бөгөөд хамгийн их буюу Улаанбаатар хотод 344 иргэн шилжсэн нь 61,4 хувь байна . Тус хэлтсээр дамжуулан 354 иргэнд цахим болон үндэсний энгийн гадаад паспорт олгосон бөгөөд 196

иргэнд шинээр, 158 иргэнд дахин олголоо. Дахин гадаад паспорт захиалж байгаа иргэдийн өмнөх паспортыг мэдээллийн санд тухай бүр хүчингүй болгож байгаа ба 158 иргэний хуучин паспортыг хүчингүй болгосон байна.

Нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд төрөлт, овог нэр өөрчлөлт, эцэг тогтоолт, үндсэн мэдээллийн санд гэрлэлтийн төлөв буруутай орсон зэрэг 74 бүртгэлийг хяналтын улсын байцаагчийн 6839 болон 4865 тоот дүгнэлтүүдийг үндэслэн засвар оруулсан. Мөн журнал бүртгэл, мэдээллийн санд эх нотлох баримт нь байгаа боловч мэдээлэл нь шивэгдэж ороогүй 42 бүртгэлийг нөхөн бүртгэлээр тухай бүрд оруулж байгаа нь үйлчилгээний шат дамжлага буурахаас гадна иргэдийн цаг хугацаа, эдийн засгийг хэмнэсэн үйлчилгээ болж чадаж байна. Иргэний бүртгэлийн үйлчилгээг өөрийн биеэр ирж авах боломжгүй иргэдэд зөөврийн төхөөрөмж ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төвтэй хамтран 2 иргэнийг биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлд хамруулан, 14 иргэнд тоон гарын үсэг олголоо. Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх зорилгоор тус хэлтэс нь Бямба гарагийн үйлчилгээг 3-р сарын 1-ний өдрөөс нэвтрүүлсэн бөгөөд ажлын өдрүүдэд завгүй байдаг төрийн албаны болон хувийн хэвшлийн албан хаагчид, малчдад үйлчилгээ авах нөхцөл бүрдсэн. Тус тасаг нийт 8 удаа Бямба гарагийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажилласан бөгөөд гадаад

паспорт захиалга, гадаад паспорт олголт, иргэний үнэмлэх олголт зэрэг үйлчилгээг 35 иргэнд үзүүллээ. Тайлант хугацаанд төрийн цахим үйлчилгээний ''Хурдан систем''-ээс гэрлэсний бүртгэлгүй лавлагаа 44, гэрлэлтийн бүртгэлийн лавлагаа 122, иргэний үнэмлэхийн лавлагаа 972,төрсний гэрчилгээний лавлагаа 414, оршин суугаа хаягийн лавлагаа 591 нийт 2143 лавлагаа мэдээллээр иргэд үйлчилгээ авсан байна. Мөн иргэний үнэмлэхээ хаяж үрэгдүүлсэн 36 иргэн хурдан системээр иргэний үнэмлэхээ захиалжээ .




Иргэний улсын бүртгэлийн тасаг нь улсын бүртгэгчдээс өдөр бүр хөтөлсөн бүртгэлийн тоон мэдээллийг авч нэгтгэн бүртгэгчдийн ажлын ачаалалд дүн шинжилгээ хийн ажиллаж байна. Төрөлт , нас баралт, шилжилт хөдөлгөөн, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл, гэрлэлт зэрэг хамгийн их гардаг бүргэлийн төрлүүд дээр бүртгэгчдийн ажлын ачаалалд анализ хийлээ. Хамгийн их бүртгэлийг Сайнцагаан сум 1234, Эрдэнэдалай сум 196, Адаацаг сум 72 бүртгэл хийсэн бол хамгийн бага бүртгэлийг Өндөршил сум 35, Цагаандэлгэр сум 38, Баянжаргалан сум 41 бүртгэлийг тус тус хийсэн байна. Сайнцагаан сумын хийсэн бүртгэл энэ таван төрлийн бүртгэл дээр нийт бүртгэлийн 62,3 хувийг эзэлж байна.

Тоон гарын үсэг олгосон мэдээ

Дундговь аймаг — 2024 оны 5 сарын 27

| № | Сумын нэр | 16-аас дээш насны нийт иргэдийн тоо | Тоон гарын үсэг авсан иргэдийн тоо | 5 сард олгосон тоон гарын үсэг | Өссөн дүнгээр | Тоон гарын үсэг аваагүй иргэдийн тоо | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Адаацаг | 1925 | 1964 | 19 | 1983 | -39 | 103 |
| 2 | Баянжаргалан | 880 | 739 | 1 | 740 | 141 | 84.09 |
| 3 | Говьугтаал | 1108 | 701 | 29 | 730 | 407 | 65.88 |
| 4 | Гурвансайхан | 1539 | 1359 | 9 | 1368 | 180 | 88.89 |
| 5 | Дэрэн | 1480 | 1166 | 2 | 1168 | 314 | 78.92 |
| 6 | Дэлгэрцогт | 1167 | 1072 | | 1072 | 95 | 91.86 |
| 7 | Дэлгэрхангай | 1592 | 1369 | 8 | 1377 | 223 | 86.49 |
| 8 | Хулд | 1697 | 1166 | 5 | 1171 | 531 | 69 |
| 9 | Луус | 1349 | 373 | 6 | 379 | 976 | 28.09 |
| 10 | Өлзийт | 1745 | 767 | 2 | 769 | 978 | 44.07 |
| 11 | Өндөршил | 1053 | 1095 | 19 | 1114 | -42 | 105.8 |
| 12 | Цагаандэлгэр | 741 | 623 | 16 | 639 | 118 | 86.23 |
| 13 | Сайхановоо | 1504 | 860 | 35 | 895 | 644 | 59.51 |
| 14 | Сайнцагаан | 10257 | 4068 | 55 | 4123 | 6189 | 40.2 |
| 15 | Эрдэнэдалай | 4007 | 3605 | 29 | 3634 | 402 | 90.69 |
| | Нийт | 32044 | 20927 | 235 | 21162 | 11117 | 66.04 |

Мэдээг нэгтгэсэн:
Тасгийн дарга, ахлах бүртгэгч /Б. Сайхантуяа/

***МУИХурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд хийсэн ажлаас:***

Монгол Улсын Их хурлын сонгуулийн ажлын хүрээнд УБЕГазар болон ИУБГазраас ирүүлсэн 10 үүрэг даалгаврын






хүрээнд дараах ажлуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

- Иргэний улсын бүртгэлийн газраас тус аймгийн хэмжээний нийт сонгуулийн насны иргэдийн тоог гаргаж ирүүлсэн бөгөөд 15 сумын 68 багийн 30450 сонгогчийн тоог Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд албан тоотоор хүргүүллээ.

- Сонгуулийн хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр,төвийг байгуулсан тухай 15 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоолыг хүлээн авч нэгтгэн тогтоолыг эх хувиар, жагсаалт албан бичгийн хамт Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүллээ. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд Монгол улсын их хурлын сонгуулийн хэсэг байгуулсан тухай тогтоолын мэдээллийг шивж, тогтоолыг скайнардан оруууллаа. Тус аймгийн хэмжээнд 15 сумын 68 багт сонгуулийн 61 хэсэг байгуулагдсан бөгөөд хэсгийн нутаг дэвсгэр, санал авах байрны мэдээлэл, хаягийн мэдээллийг шивж оруулан баталгаажуулалт хийсэн. Мэдээллийг үнэн зөв шивж баталгаажуулсан бөгөөд мэдээлэл шивж баталгаажуулахад программд ямар нэг хүндрэл учраагүй. Тогтоолын эх хувийг ИУБГазарт хүргүүлсэн.

- Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газраас 2024 оны 02 сарын 5-ны өдөр ирсэн 3/1578 тоот албан бичгээр www.burtgel.gov.mn цахим хуудас , www.check.burtgel.gov.mn хаягаар өөрийн байнга оршин суугаа хаягт бүртгэлтэй иргэдийн мэдээллийг шалгаж мэдээлэл зөрүүтэй, манай хаяг дээр байхгүй иргэн бүртгэлтэй байна гэж 6 иргэн мэдээлэл ирүүлсэн байна. Тус мэдээллийг шалгаж үзэхэд Ханджав овогтой Уянгын мэдээлэл 3 удаа бүртгэлтэй байгаа бөгөөд нийт 4 иргэний зөрүүтэй гэсэн мэдээллийг санд шалган, иргэнтэй утсаар холбогдож мэдээллийг тодруулан зөвлөгөө өгч ажиллалаа.

- УБЕГазрын Тамгын Газраас 2024 оны 03 сарын 15-ны өдрийн 2/3440 тоот албан бичгээр сонгуулийн хэсэг байгуулсан сум дүүргийн ИТХурлын тогтоолыг хүлээн авч нягтлан шалгахад election.gasr.mn программд мэдээлэл зөрүүтэй шивж оруулсан аймгууд мэдээллээ засах талаар мэдээлэл ирсэн бөгөөд тус аймаг дурдагдаагүй.

- Цахим хуудаст танилцсан сонгогчийн мэдээлэл программд нийт 1026 иргэн мэдээллээ шалгасан бөгөөд мэдээлэл зөрүүгүй гэж 1013 иргэн мэдээлсэн бол мэдээлэл зөрүүтэй гэж 13 иргэн мэдэгдэл ирүүлснийг тухай бүр иргэдтэй холбогдон шийдвэрлэж ажилласан.

- 2024 оны 04 сарын 3-ны өдрийн 3/4272 тоот албан бичгээр шилжилт хөдөлгөөний бүртгэл хэтлөхтэй холбоотой улсын бүртгэгчид иргэдээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг эх хувиар нь нэхэх, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд байгаа мэдээллийг нэхэж бүртгэл хэтлөхгүй зэрэг асуудлыг гаргаж байгаа тул арга хэмжээ авч ажиллах талаар чиглэл ирүүлснийг улсын бүртгэгчдэд танилцуулан 3/10685 чиглэлийг мөрдөж ажиллахыг үүрэг болгосон.

- УБХэлтсээс 2024 оны 04 сарын 1-ны өдрийн ,,,,тоот албан бичгээр шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой чиглэлийг хүргүүлсэн.

- УБЕГазрын даргын 2024 оны 04 сарын 16-ны өдрийн 1/4924 тоот чиглэлийг хүлээн авч илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлсэн.

- Шилжилт хөдөлгөөний бүртгэл зогссон тухай Улсын бүртгэлийн Ерөнхий Газрын даргын 2024 оны 04 сарын 25-ны өдрийн А/61 тоот албан бичгийг хүлээн авч улсын бүртгэгчдэд танилцууллаа. Тус аймаг 2024 оны 4 сарын 26-ны 18 цагийн байдлаар

нийт 718 шилжилт хөдөлгөөний бүртгэл хийсэн бөгөөд гадны аймаг хотоос шилжин ирсэн 16-аас дээш насны 213 иргэн, 16-аас доош насны 129 иргэн, аймаг доторх шилжилт хөдөлгөөн сумаас суманд 16-аас дээш насны 92 иргэн, 16-аас доош насны 81 иргэн, багаас багт шилжсэн 16-аас дээш насны 112 иргэн, 16-аас доош насны 91 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгэсэн байна. Шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуулийн хугацаанд баталгаажуулж дууссан бөгөөд цахимжуулаагүй бүртгэл байхгүй.

- ИУБГазрын даргын 2024 оны 04 сарын 26-ны өдрийн 3/5531 тоот албан бичгээр УБЕГазрын даргын 2024 оны 04 сарын 25-ны өдрийн А/61 тоот ‘’Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох тухай’’тушаалыг хүлээн авч мэдээллийг хүргэж ажиллалаа.




Цахим хуудаст нийт 1026 сонгогч мэдээлэлээ шалгаж баталгаажуулсан бөгөөд мэдээлэл зөрүүгүй гэж 1013 иргэн мэдээлсэн бол хаяг зөрүүтэй гэж 11 иргэн мэдээлснийг иргэдтэй холбогдож шийдвэрлэж ажилласан. 2 иргэн мэдээлэл нь зөв боловч андуурч мэдээлсэн гэж мэдэгдсэн.

***4-рт Сургалт, сурталчилгаа:***

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд УБЕГазрын вэйбсайт болон фэйж хуудас, Улсын бүртгэлийн хэлтсийн фэйж хуудсанд байршигдсан мэдээ мэдээллийг шэйрлэж түгээхээс гадна тус тасгаас иргэний үнэмлэхээ цаг хугацаанд нь авахад иргэдэд анхааруулсан пост, гадаад паспорт хэвлэгдэн ирсэн тухай зурган мэдээлэл, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой мэдээлэл 16 удаа бэлтгэн түгээхэд 4125 иргэн хандаж мэдээлэл авсан байна. Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбоотой 1, 24/7 үйлчилгээтэй холбоотой 3 нийт 4 контент бэлтгэж иргэдэд хүргэсэн. 1788 иргэн хандаж мэдээлэл авсан . Жил бүрийн 5 сарын 1-нд иргэдэд хуулийн зөвлөгөөг үнэ төлбөргүй өгдөг, байгууллагууд хууль эрх зүйн сурталчилгааг зохион байгуулдаг хуульчийн ‘’Про Боно’’ нээлттэй өдөрлөгт иргэний бүртгэлийн мэдээ мэдээлэл хүргэн гарын авлага тараах материалыг иргэдэд хүргэж ажиллалаа.



Дэлгэрцогт суманд 5 сарын 15-ны өдөр зохион байгуулагдсан ‘’Малчдын нэг өдөрлөгт’’ тус хэлтэс 4 жи төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээг хүргэлээ. Гадаад паспорт захиалга 16, тоон гарын үсэг 13, гэрлэлт бүртгэл 2, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 3, мэдээлэл зөвлөгөө 19 нийт 53 иргэн бүртгэлийн үйлчилгээ авлаа. Мөн өдөр олон улсын гэр бүлийн өдөр тохиож гэрлэлтээ албан ёсоор батлуулсан Б. Бямбадорж , Г.Мөнхчимэг нарын гэрлэх ёслолыг зохион байгууллаа. МУИХурлын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд улсын бүртгэгчдэд зохион байгуулсан ‘’Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийн талаар’’ чиглэл өгөх сургалтыг 2024 оны 01 сарын 29-ны өдөр зохион байгуулсан. ‘’ Шилжилт хөдөлгөөний бүртгэлийн тухай ойлголт, бүртгэл хэрхэн хөтлөх’’ сэдвээр ахлах бүртгэгч Б. Сайхантуяа, ‘’Шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөхөд гарч буй алдаа зөрчил анхаарах асуудал’’ сэдвээр хяналтын улсын байцаагч Д. Нямсүрэн нар зохион байгуулсан сургалтад нийт 17 улсын бүртгэгч хамрагдлаа. 2024 оны 1 сарын 30 -ны өдөр МУИХ-ын сонгуулийн тухай хууль, түүнд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар чиглэл өгөх сургалтыг хэлтсийн албан хаагчдад танхимаар, сумдын улсын бүртгэгчдэд цахимаар зохион байгууллаа. МУИХ-ын сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, сонгуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хэлтсийн дарга Ж. Өлзийжаргал, ‘’Сонгогчийн нэрийн жагсаалт үйлдэх анхаарах асуудал ’’ сэдвээр ахлах бүртгэгч Б. Сайхантуяа нар мэдээлэл бэлтгэж хүргэлээ. Нийт 28 албан хаагч хамрагдлаа.






**2-рт ЭХХЭУбүртгэлийн чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд:**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын болон Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтсийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хийж хэрэгжүүлэхээр тусгагдсан ажил, арга хэмжээний дагуу Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан хэлтсийн даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу болон Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх журам, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим систем EPRS-д хөтлөх журам, бусад үйл ажиллагаандаа мөрдвөл зохих хууль, дүрэм, журам, чиглэл, хэлтсийн даргын өгсөн үүрэг даалгавар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын ХЭЭХЭУБГ-ын даргаас ирүүлсэн чиглэл болон хүний нөөцийн программ дахь сургалтуудыг бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус тасаг нь тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Л.Мөнхсарнай, эд хөрөнгийн улсын бүртгэгч О.Ганцэцэг, улсын бүртгэгч Н.Угантуяа, Дэлгэрхангай сумын бүртгэгч Гэрэлтуяа, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Б.Одонтунгалаг нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэн ажиллаж байсан ба Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 5-р сарын 15-ны өдрийн Б/297 тоот тушаалаар Сайнцагаан, Сайхан-Овоо, Дэрэн, Хулд, Говь-Угтаал сумын бүртгэгчид эд хөрөнгийн улсын бүртгэл хөтлөх эрх, Б/298 тоот тушаалаар Сайнцагаан, Сайхан-Овоо, Дэрэн, Хулд, Говь-Угтаал, Дэлгэрхангай сумын бүртгэгчид хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгосноор 6 суманд хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх боломжтой болсон.

**<u>Үүрэг даалгавар, чиглэл, зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийн талаар:</u>**

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын даргын бичгээр ирүүлсэн 19 удаагийн албан даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Хэрэгжилтийн талаарх хариуг илтгэх хуудсаар хугацаанд нь хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын даргын тамгын газраас ирүүлсэн үүрэг даалгавруудыг зохион байгуулан хариуг хугацаанд нь хүргүүлэн ажиллалаа. Үүнд:

2024.01.23-ны өдрийн 01/23 тоотын дагуу “Жендэрийн мэдрэмжтэй ажлын байрны бодлого” сарын аяныг зохион байгуулж тайланг хугацаанд нь хүргүүлсэн

2024.02.16-ны өдрийн 08/191 тоотын дагуу Монгол улсын олон улсын гэрээ “Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай” конвенцийг хэрэгжүүлэх 2024 оны төлөвлөгөөний саналыг нэгтгэн хүргүүлсэн.

2024.03.04 08/272 тоотоор ирүүлсэн “Харилцан хүндэтгэе” сарын аяныг удирдамжын дагуу зохион байгуулж тайланг хугацаанд нь хүргүүлсэн

Тасгийн бүртгэгч нар хэлтсийн даргаас өгсөн 6 үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь амжилттай хийж гүйцэтгэн илтгэх хуудсаар тайлагнасан ба “Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх”, “Өмч хамгаалах зөвлөл”, “Хэлтсийн баримт бичиг нягтлан шалгах комисс”-ийн болон дэд төлөвлөгөөнүүдийн төлөвлөгөө, биелэлтийг хугацаанд нь гаргаж ажиллалаа.

## ХОЁР. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн хуулиар хүлээсэн үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгч нарын өдөр тутмын үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр хангах, хяналт тавих, улсын бүртгэлийн эх нотлох баримтын үнэн зөвийг хангаж цахим болон цаасан мэдээллийн санг эрхлэн хөтлөх, хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, улсын бүртгэл алдаагүй, үнэн зөв байх байдлыг хангах чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг нийт **1436** мэдүүлэг хүлээн авч бүртгэл хийснээс **274** анхны бүртгэл, эрх шилжүүлэх бүртгэл **216**, бүртгэлд өөрчлөлт оруулах **73**, барьцааны гэрээ **367**, барьцааны гэрээ дуусгавар болох **471**, лавлагаа, хуулбар **34**-ийг бүртгэж, үйлчилгээний хураамж **17,7** сая, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулснаас оруулсан татварын орлого **60.1** сая, тэмдэгтийн хураамж **1.1** сая, улсын төсөвт нийт **78.9** сая төгрөгийн орлого оруулаа. /2023.12.26-2024.05.25-ны байдлаар/ Үүнд:

**Газар өмчлөх эрхийн гэрчилгээний улсын бүртгэл 677**

- Төрөөс хувьчилсан газрын өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 161
- Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх 6
- Газар өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл **132**
  - Худалдах худалдан авах гэрээ 78
  - Бэлэглэх гэрээ 27
  - Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 15

- Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх 11
- Барьцааны гэрээ бүртгэх **129**
- Барьцааны гэрээ дуусгавар болгох **194**
- Бүртгэлд өөрчлөлт оруулах **48**
  - Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр авах **8**
  - Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх **6**
  - Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх **9**
  - Эд хөрөнгийн хэмжээ, үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх 24
- Лавлагаа хуулбар олголт **2**
- Хувийн хэрэг хаах **5**
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо **345**

**Газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээний улсын бүртгэл 759**

- Шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 59
- Өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээ хэлцлээр бүртгэл салгаснаар шинэ бүртгэл үүсэх 17
- Газраас бусад үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийг анх удаа бүртгэх 36
- Өмчлөх эрх шилжих гэрээ **84**
  - Худалдах худалдан авах гэрээ 48
  - Бэлэглэх гэрээ 16
  - Арилжих гэрээ 1
  - Өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх 7
  - Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдөх 2
  - Өмчлөгч өөрт ногдох хэсгээ худалдах 2
  - Өмчлөгч өөрт ногдох хэсгээ бэлэглэх 1
- Барьцааны гэрээ бүртгэх **238**
- Барьцааны гэрээ дуусгавар болгох **277**
- Түрээсийн гэрээ **1**
- Бүртгэлд өөрчлөлт оруулах **25**
  - Үрэгдүүлсэн гэрчилгээ шинээр авах 1
  - Гэмтээсэн гэрчилгээ шинээр олгох 2
  - Өмчлөгчийн хүсэлтээр бүртгэл салгаснаар хэмжээ өөрчлөгдөх 1
  - Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх 8
  - Эд хөрөнгийн зориулалт өөрчлөгдөх 1
  - Эд хөрөнгийн хэмжээ, үнэ гүйцэтгэл өөрчлөгдөх 12
- Лавлагаа хуулбар /албан бичиг/ **22**
- Хувийн хэрэг хаах **5**
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо **215**

Шинээр баригдсан 2 орон сууцны хувийн хэргийг цахимжуулж илтгэх хуудсыг ЭХЭУБ-ийн газрын ахлах мэргэжилтэн Сувд-Эрдэнийн www.e.suvderdene@burtgel.gov.mn хаягаар 2024.04.05-ны өдөр хүргүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг нь тасгийн хурлыг хэлтсийн дарга, хяналтын улсын байцаагчийн бүрэлдэхүүнтэй өргөтгөсөн байдлаар 2, тасгаараа 2 нийт 4 удаа хуралдуулж, ЭХЭУБГ-аас ирүүлсэн чиглэлийг танилцуулж, өгсөн үүрэг даалгаврын дагуу бүртгэгчдийн ажил үүрэгт чиглэл өгөх, бүртгэлд хяналт хийж зөвлөн туслах болон дотоод асуудлуудыг цаг тухайд нь шийдвэрлэж ирсэн

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хяналт шалгалтын газрын хяналтын улсын байцаагч Э.Нандинлхамын хяналт шалгалт хийн улсын байцаагчийн 2024 оны 01сарын 23-ны өдрийн 17 тоот албан шаардлагаар илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай үүрэг даалгавар өгсний дагуу хэлтсийн хяналтын улсын байцаагчид 3 удаагийн тайлбар гарган Хяналтын улсын байцаагчийн 965, 966, 1154 тоот дүгнэлтээр 18 бүртгэлийг зөрчлийг, Хяналтын улсын ахлах байцаагчийн 2022 оны 1500 дүгнэлтэд хамаарах 13 бүртгэлийг тус тус засварлан илтгэх хуудсыг 2024.03.07-ны өдөр хүргүүллээ.

УБЕГ-ын хяналтын улсын байцаагчийн 2022 оны 1500 дүгнэлт болон эх нотлох баримтыг үндэслэн бүртгэлд засвар өөрчлөлтийг 12 удаа хийн бүртгэлийн дэвтэр хөтлөн хэвшсэн.

Улсын байцаагч нар бүртгэл хийх бүрдээ урьд эх нотлох баримтуудын дугаарлалтыг хянаж тулган үздэг ба **4** хувийн хэргийн дугаарлалтын алдааг илрүүлж, дараагийн бүртгэл хийх явцдаа залрууллаа. Засвар өөрчлөлтийн мэдээг сар бүр батлагдсан маягтын дагуу гарган www.edkhurungu.gov.mn хаягаар иогээж хэвшсэн.

Бүртгэгч нарын үнэт цаасны зарцуулалтын тооцоог сар бүр авч, хяналт тавин ажиллаж байгаа ба энэ онд бүртгэгчид газрын **345**, үл хөдлөх эд хөрөнгийн **215** нийт **560** үнэт цаас зарцуулсан ба 4 үнэт цаасыг техникийн саатал болон бүртгэгчийн буруугаас хүчингүй болгосон байна.

Эд хөрөнгийн **1436** бүртгэлийг хийхдээ дугаарлалтыг цахим хувийн хэргээс болон шаардлагатай тохиолдолд цаасан нотлох баримтаас нягтлан бүртгэлийг хийж гүйцэтгэж байна. Тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Н.Угантуяа, О.Ганцэцэг нарын 1-р улирлын бүртгэлийн хугацаа хэтрэлтэд хяналт хийж бүртгэгч нарт танилцууллаа.

Дэлгэрхангай сумын бүртгэгч Гэрэлтуяагийн архивт шилжүүлсэн 12 бүртгэлд хяналт хийн, заавар зөвлөгөөг тухай бүрд нь утсаар үзүүллээ.

Мөн 4-р сард эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байгаа бүртгэгч нарын хүлээн авсан мэдүүлгийг төрлөөр нь ангилан сүүлийн 3 жилийн байдлаар, мөн 2024.04.01-2024.04.05-ны өдрүүдэд хүлээн авсан бүртгэлд дүгнэлт хийн хэлтсийн даргад танилцуулсан.Үүнд:

Сүүлийн 3 жил эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байдал:




2024 оны 1 дүгээр улирлын байдлаар 4 бүртгэгч нийт 742 мэдүүлэг хүлээн авсан байна. Графикаар бүртгэгч нарын хүлээн авсан бүртгэлийг харуулав.



Дэлгэрхангай сумын бүртгэгч Ц.Гэрэлтуяа нь 2022 оны 2-р сарын 10-ны өдрөөс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг хийж эхэлсэн бөгөөд ойролцоо орших Хулд, Эрдэнэдалай, Сайхан-Овоо сумын бүртгэлийг сумандаа хүлээн авдаг. 2022.02.10-2024.04.09-ны байдлаар хүлээн авч бүртгэсэн мэдүүлгийн тоо.




Бүртгэгч нарын 7 хоногоор авсан бүртгэл 2024.04.01-2024.04.05



Хуулийн этгээдийн чиглэлээр

2024 оны 1-р улирлын байдлаар хуулийн этгээдийн оноосон нэрийг e-business.mn хүлээн авч татгалзсан 325, зөвшөөрсөн 83 , баталсан 19 нийт 541 оноосон нэрийн бүртгэсэн.









Тайлант хугацаанд нийт **1436** мэдүүлэг хүлээн авч үйлчилгээ үзүүлснээс анхны бүртгэлийн **274** бүртгэлд шинээр хувийн хэрэг үүсгэн, өмчлөх эрх шилжих гэрээ, барьцааны гэрээ, бүртгэлд өөрчлөлт оруулах зэрэг **1127** бүртгэлийн өөрчлөлтийн ойролцоогоор **6762** хуудас баримтыг архивт хүлээлгэн өглөө.

Хэлтсийн архивт хадгалагдаж байгаа э дугаар олголтын **2778** хувийн хэрэг хадгалагдаж байгааг архивын нэгж үүсгэн хавтасласан.

Архивын мэдээг www.g.khuchitbaatar.burtgel.mn хаягаар сар бүрийн 26-ны өдөр илгээж хэвшсэн. Газрын 12239**,** газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 4715, э дугаартай 2778 нийт **19735** хувийн хэрэг архивт нээгдэн хадгалагдаж байна.

Хэлтсийн даргаас өгсөн үүргийн дагуу авлигатай тэмцэх газарт 7, татварын хэлтэст 7, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 15, ИХАШ шүүхэд 1, аймгийн цагдаагийн газарт 5, иргэний мэдүүлгээр 3 нийт 38 лавлагааг хууль хяналтын байгууллагад хүргүүллээ. Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн https://erp.e-mongolia.mn/, edoc.mojha.gov.mn системийг үйл ажиллагаанд хэрэглэж хэвшсэн ба цаг үеийн чанартай орон нутгийн болон төрийн албаны үйл ажиллагааны мэдээ мэдээллийг хүлээн авч, албан бичиг хүлээн авах, хариуг илгээх зэрэг эргэх холбоотой ажиллаж төрийн албаны шуурхай байх нөхцлийг бүрдүүлж байна.

Сар бүрийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээний мэдээ, орон сууц, хувийн сууцны, архивын, шинээр баригдсан орон сууцны хувийн хэргийг баталгаажуулах, алгассан дугаарын зэрэг мэдээ, судалгаануудыг батлагдсан маягтын дагуу гаргаж сар бүрийн 26-ны өдөр www.edkhurungu.burtgel.gov.mn хаягаар илгээж хэвшлээ. Сарын мэдээг инфографикт оруулж өмнөх оны мөн үе,энэ оны мөн үетэй харьцуулж мэдээлэл бэлтгэн хэлтсийн сайтад байршуулдаг ба орлогын тайланг сар бүр гэргэн санхүүд илгээж байна.

## ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Сургалтын төлөвлөгөөг 17 агуулгын хүрээнд 24 чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ явуулахаар төлөвлөн ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 60 хувьтай.

1. Мэргэшсэн нягтлан бодогчдын институттай хамтын ажиллагааны гэрээ байгуулан тус хэлтсийн нягтлан бодогчийг мэргэшүүлэх бүсийн сургалтад хамруулж 204,0 төгрөгийн төлбөрийн дэмжлэг үзүүлэв.
2. Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалтад хэлтсийн дарга суралцахаар гэрээ байгуулав.
3. АЕГазраас зохион байгуулсан мэргэшүүлэх сургалтад Байгууллагын архив хөтлөлт цахимжуулалт сэдвээр архивч, бичиг хэргийн ажилчид хамрагдав
4. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг 4/7/10 сургалтад хэлтсийн албан хаагчид тогтмол хамрагдаж хэвшив.
5. Аймгийн тагнуулын хэлтэстэй хамтран ажиллаж Төрийн болон албаны нууцын тухай хууль журмыг хэрэгжүүлж ажиллах зааварчилгаа, террорист халдлага, цахим халдлага зэрэг сэдвүүдээр 2 удаагийн сургалтыг танхимаар албан хаагчдад хийлээ.

**<u>3.1. Улсын бүртгэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа хууль, дүрэм, журмыг сурталчилах талаар:</u>**

Улсын бүртгэлийн ерөнхий газрын www.burtgel.gov.mn, хэлтсийн www.dundgovi.burtgel.gov.mn сайтууд болон facebook хаягаар цацагдаж байгаа мэдээ, мэдээллүүд, видео, контентуудыг цаг тухай бүрд нь олон нийтэд түгээн ажиллаж байна. Сумдын facebook группүүдэд зөөврийн тоног төхөөрөмжөөр бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх тухай зурагт баннер хийж түгээж байна.

Эхний хагас жилд Киоск-оор эд хөрөнгийн лавлагаа 26, эд хөрөнгөтэй эсэх лавлагаа 9 нийт **35**, Төрийн үйлчилгээний цахим системээр үл хөдлөх эд хөрөнгийн лавлагаа **168**, үл хөдлөх эд хөрөнгө өмчилж байгаа болон шилжүүлсэн тухай лавлагаа **129** нийт **297** лавлагаа авсан байна.

Нэг цэгийн үйлчилгээний танхимын төлбөрийн D83 төхөөрөмжөөр **1162** иргэн төлбөр тооцоо хийж үйлчилгээ авсан байна.





Зөөврийн тоног төхөөрөмжөөр 2024.05.01-ний өдөр Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Пробоно” өдөрлөгт эд хөрөнгийн чиглэлээр 6, хуулийн этгээдийн 8,




2024.05.15-ны өдөр Дэлгэрцогт сумын малчдын өдөрлөгт оролцож эд хөрөнгийн 12, хуулийн этгээдийн чиглэлээр 3 нийт **29** иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүллээ.




Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 7-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн талаар банкны үйлчилгээ эрхэлж байгаа 3 банк, 5 банк бус байгууллагад хэлтсийн даргын 2024.03.12-ны 03/119, 2 нотариатч, сумдын нотариатчын үүрэг гүйцэтгэгч нарт 2024.03.12-ны 03/118 тоот албан бичгээр чиглэл хүргүүллээ.



ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

ЗДТГ-ын байр, 7 дугаар баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48101
Утас: 7059 2435, Факс: (976) 7059 2435,
Цахим шуудан: dundgovi@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.burtgel.gov.mn

2024.03.12 № 03/119

танай ____________ -ны № ____________ -т

АЙМГИЙН БАНК, БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН УДИРДЛАГАД

Хамтран ажиллах тухай

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт "газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ;" гэж улсын бүртгэлд тусгах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй;" гэж заасан байгаа тул барьцааны гэрээ байгуулж ЭУБ-06 маягт үйлдэхдээ барьцаа хөрөнгийн мэдээлэл хэсгийн бусад гэсэн талбарт барьцааны зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийн үнийг дурдаж, тус үл хөдлөх эд хөрөнгийн хамгийн сүүлд бүртгэгдсэн үнийн дүнг лавлагаагаар авч хамтран ажиллахыг хүсье.

Хавсралтаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024.02.23-ны өдрийн 5/2366 албан бичгийг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
Удирдлага
Хэлтсийн дарга
Жамбал Өлзийжаргал
2024.03.12 10:01



ДУНДГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

ЗДТГ-ын байр, 7 дугаар баг, Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48101
Утас: 7059 2435, Факс: (976) 7059 2435,
Цахим шуудан: dundgovi@burtgel.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.burtgel.gov.mn

2024.03.12 № 03/118

танай ____________ -ны № ____________ -т

АЙМГИЙН ТОЙРГИЙН НОТАРИАТ БОЛОН НОТАРИАТЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ НАРТ

Хамтран ажиллах тухай

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр орсон нэмэлт өөрчлөлтөөр хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт "газрын эрх, үл хөдлөх эд хөрөнгийг барьцаалах тохиолдолд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн барьцааны гэрээ, эсхүл барьцаалбарт тусгагдсан тухайн эд хөрөнгийн барьцааны үнэ;" гэж улсын бүртгэлд тусгах үл хөдлөх эд хөрөнгийн үнийг тодорхойлж, 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "Энэ хуулийн 9.1.5-д зааснаас бусад тохиолдолд энэ хуулийн 9.1.3, 9.1.4-т заасан үнийг хамгийн сүүлд бүртгэгдсэн үнээс бууруулж бүртгэхгүй;" гэж заасан байгаа үл хөдлөх эд хөрөнгийн эрх шилжих гэрээ байгуулах, барьцааны гэрээг баталгаажуулахдаа тус үл хөдлөх эд хөрөнгийн хамгийн сүүлд бүртгэгдсэн үнийн дүнг лавлагаагаар авч хамтран ажиллахыг хүсье.

Хавсралтаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024.02.23-ны өдрийн 5/2366 албан бичгийг хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

Дундговь аймгийн улсын бүртгэлийн хэлтэс
Удирдлага
Хэлтсийн дарга
Жамбал Өлзийжаргал
2024.03.12 10:02

**3.2.УБЕГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдсан байдал:**

2024.01.09-нд УБЕГ-н бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газраас зохион байгуулсан “Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах” анхаарах асуудлууд сургалт

2024.01.26-нд УБЕГ-ын эрхзүйн хэлтсээс зохион байгуулсан “Сөрөг мэдээлэл, сөрөг зүйлээс өөрийгөө хамгаалахуй”

2024.04.09-нд УБЕГ-ын ЭХЭУБГ-аас Хуулинд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар Банк, банк бус байгууллагуудын удирдлага, нотариатчдын танхимын удирдлагуудтай хийсэн хэлэлцүүлэгт цахимаар оролцсон

2024.04.26-нд УБЕГ ХЭУБГ-аас зорион байгуулсан ХЭЭХЭУБТасгийн дарга, улсын ахлах бүртгэгч нарт зориулсан сургалт

Дотоод сургалт: Хэлтсийн даргаас зохион байгуулсан

2024.01.05-ны өдөр “ Ажил, амьдралын тэнцвэр” сургалт






2024.01.30-нд МУИХурлын тухай хуульд оруулсан нэмэл, өөрчлөлтийн тухай

2024.02.21-нд “Цахим аюулгүй заналхийлэл”

**3.3. Улсын бүртгэгчдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, сургалт зохион байгуулан бүртгэлийн үйл ажиллагаанд заавар зөвлөмж өгч ажилласан талаар**

Сумдын бүртгэгч нарт Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр нийт 4 удаа цахимаар сургалт зохион байгуулсан ба өдөр тутмын зааварчилга, удирдлагаар ханган ажиллаж байна.

## ДӨРӨВ: ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай, хууль журмын дагуу үзүүлэх, үйл ажиллагаагаа иргэдэд сурталчлах, холбогдох сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт тавин ажиллалаа.Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох журмын дагуу хуулийн этгээдийн бүртгэлийг хийсэн.

### 4.1 УЛСЫН БҮРТГЭЛИЙГ ХУУЛЬ ТОГТООМЖ, ХОЛБОГДОХ ЖУРМЫН ДАГУУ ХӨТЛӨХ

Иргэний хууль, Улсын бүртгэлийн тухай ерөнхий хууль, Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай, бусад холбогдох хууль, “Хуулийн этгээд, түүний салбар төлөөлөгчийн газрын бүртгэл хөтлөх журам, Хуулийн этгээдийн ерөнхий газраас “Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 2023.01.18-ны өдрийн 03/163 дугаартай Монгол улсын иргэнийг гадаадад ур чадварын дадлагажигчаар зуучлах тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн судалгаа жагсаалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 04 сарын 13-ны өдрийн 3/1514 тоот чиглэл, УБЕГ-н даргын 2023.06.29-ны 4/ 6218, 2023.01.10-ны өдрийн 4/1690 2023.01.11-ны өдрийн 5/334, 2023.05.08-ны өдрийн 4/4386 тоот албан бичгийг чиглэл болгон дагуу дараах бүртгэлийг улсын бүртгэлд бүртгэсэн.

Үүнд:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгосон 14,
Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан нэмэлт өөрчлөлт 85,
Иргэн, хуулийн этгээдэд лавлагаа олгосон 20 ,
Салбар төлөөлөгчийн газар бүртгэсэн 2
Шашны байгууллага хугацаа сунгасан-3,
Шинээр хуулийн этгээд бүртгүүлсэн нийт 102 ХХК 42, хоршоо 50 , төрийн бус байгууллага 10, нийт 209 бүртгэл хийж архивт 1500 хувийн хэрэг байршиж байна.

Тамга тэмдэг баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих лавлагаа олгох журам”-д зааснаар тамга, тэмдгийн хяналтын дугаар олгосон шинээр ххк 76 , дахин хяналтын дугаар олгосон 20, нийт 94, хураан авсан тамга 20 тэмдгийг архивт шилжүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлээс орон нутгийн орлогод 9044,0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн.

Хэлтсийн даргаас өгсөн үүргийн дагуу авлигатай тэмцэх газарт **5**, цагдаа 5, шүүхрүү 3 татварын хэлтэст **4** албан бичгийг хуулийн хугацаанд хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт 5 бүртгэлийн тоон мэдээ, инфо график мэдээг 5 удаа, Архивын тоон мэдээг 5 удаа сарын бүрийн 25 -наар тасалбар болгон хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн оноосон нэрийг e-business.mn хүлээн авч татгалзсан 520**,** зөвшөөрсөн 111, баталсан 10, цуцалсан 196 нийт **860** оноосон нэрийн бүртгэлийг баталгаажуулсан.

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр сумдын улсын бүртгэгч нарт тухай бүр мэдээллийг утсаар болон цахимаар хүргэж шинэ хоршоо хөдөлгөөнөөр Сайхан Овоо 1, Говь Угтаал 2, Цагаандэлгэр , Баянжаргалан 3, Өндөршил 2, Эрдэнэдалай 1 Луус 2 зэрэг нийт 14 бүртгэлийг хийсэн байна.

Монгол улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа” Шинэ хоршоо” хөдөлгөөн эхэлсэнтэй холбогдуулан 16 иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлсэн.

Үнэт цаасны тооцоог сар бүр тайлант хугацаагаар гарган баталгаажуулан няравт өгч нийт улсын бүртгэлийн гэрчилгээ 98, салбарын гэрчилгээ **2** тус тус зарцуулсан.

## ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ИРГЭД ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЛЭХ, СУРТАЛЧЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

1. Монгол улсын Их хурлаас баталсан ”Мөнгөн зээлийн үйл ажиллаагааг зохицуулах тухай, Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгө зээлийн үйл ажиллагааг бүртгүүлэх, үйл ажиллагааг хасах тухай мэдээллийг үйл ажиллагаа явуулж байгаа 4 аж ахуй нэгжид мэдээлж 1 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа хасч, 2 аж ахуй нэгж хуулийн дагуу зөвшөөрлөө авах хүсэлтээ холбогдох газарт хүргүүлсэн.
2. “Шинэ хоршоо”хөдөлгөөн эхэлсэнтэй холбогдуулан Дундговь аймгийн ЗДТГазрын хэвлэл мэдээллийн албанд яриа өгч иргэдийг мэдээллээр хангаж ажилласан.

3. EPRS.mn Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн харах эрхийг нээлгэж компани байгуулах хаягийн нотлох баримт 2 хэвлэж үйл ажиллагаандаа хэрэглэсэн.

## 4.3 УБЕГ, АЙМАГ ОРОН НУТАГ БОЛОН ХЭЛТСЭЭС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

1. edoc.mojha.gov.mn хаягаар хэлтсийн даргаас нийт 44 албан бичиг цохогдон ирснээс ирсэн 20, явсан 24 бичгийг хуулийн хугацаанд нь хариуг хүргүүлсэн.

2.Дундговь аймгийн эрүүл мэндийн 2024 оны 03 дугаар сарын 19-ны 01/154 тоот албан тоотын дагуу эрчүүдийн судалгааг холбогдох газарт хүргүүлсэн.

## 4.4 СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН, ХАМРАГДСАН ТАЛААР

- Хүний нөөц сургалтын нэгдсэн системд байршуулсан Эрх зүйн хэлтсийн сонин хэсгийн цахим сургалтад хамрагдсан.
- Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр сумдын улсын бүртгэгч нарт тухай бүр мэдээллийг утсаар болон цахимаар хүргэж шинэ хоршоо хөдөлгөөнөөр Сайхан Овоо 2, Говь Угтаал 1, Цагаандэлгэр 5, Баянжаргала 6, Өндөршил 1 , Эрдэнэдалай 8, Адаацаг 4, Луус 1 зэрэг нийт 28 бүртгэлийг хийсэн байна.
- 2024 оны 03-р сарын 12-ны өдөр Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж буй ТББ-ын дарга, гишүүдэд мэдээлэл өглөө.
- 2024 оны 02-р сарын 21-ны өдөр хэлтсийн даргын “Албаны нууц болон цахим орчин дахь аюулгүй байдал”анхаарах асуудлын талаар танхимаар зохион байгуулсан сургалтад хамрагдлаа.
- ”Бид нэг гэр бүл-Ажил амьдралын тэнцвэр” сургалт УБХ-ийн даргын өгсөн сургалтад хамрагдлаа.
- “Шинэ хоршоо”хөдөлгөөний говийн бүсийн нээлтэнд дэлгэрхангай сумын улсын бүртгэгч Гэрэлтуяагын хамт оролцож мэдээлэл авлаа.
- Сумдын улсын бүртгэгч нарт хоршоо хэрхэн бүртгэх талаар 2 удаагийн онлайн сургалт зохион байгуулсан.
- 2024.05.01-ний өдөр Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулдаг “Пробоно” өдөрлөгт эд хуулийн этгээдийн 8, 2024.05.15-ны өдөр Дэлгэрцогт сумын малчдын өдөрлөгт оролцож хуулийн этгээдийн чиглэлээр 3 нийт иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүллээ.
- Хэлтсийн даргын чиглэл болгосны дагуу “ Эрүүл мэндээ анхаарах асуудлаар эрүүл хооллолтын багш Ш.Нарангэрэлийг урьж “ Усыг хэрхэн зөв уух” талаар сургалт авч мөн Хэлтсийн албан албан хаагч нарт чиглэсэн эерэгжүүлэх сургалтыг зохион байгуулсан.

## 4.4 БАЙГУУЛЛАГЫН ГЭР БҮЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ХҮРЭЭНД

Гэр бүлийн зөвлөлийн гишүүдийн хамтаар “ Олон улсын эмэгтэйчүүдийн баяр, Эр цэргийн баярыг хамтатган зохион байгуулан баярт хэлтсийн 14 албан хаагчид оролцож хэлтсийн гарын бэлэг өглөө.

2. Гэр бүл гишүүддээ Г.Алтан Од ээждээ, Ганцэцэг Ээждээ гэнэтийн бэлэг, хэлтсийн даргын мэндчилгээ илгээсэн зурвасыг  илгээж дурсамжит өдөр болгон тэмдэглэн өнгөрүүллээ.
3.Гэр бүлийн зөвлөлөөс малчдад туслах аянд нэгдэж хандив өгөх ажлыг зохион байгуулан 300 мянган  төгрөгийг аймгийн  6 малчинд хандив өгсөн.

## 3-РТ МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, МТЕХНОГИЙН ЧИГЛЭЛЭЭР  АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД:

**Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмж, сүлжээний эвдрэл гэмтлийн засвар үйлчилгээ, программын шинэчлэлт хийх зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа. Үүнд:**

-Эд хөрөнгийн 2 бүртгэгч, Иргэний 2 бүртгэгч нарын компьютерт Canon D6010, Canon D70000, HP laserjet pro m428f сканнерыг таниулж  суулгалаа.
-Microsoft office license дууссан хэлтсийн 5 албан хаагчийн компьютерт компьютерт license update хийн шинэчиллээ.
-Хяналтын улсын байцаагчын компьютерийн дэлгэц шатсан тул шинэ дэлгэц тавьж суурилаа.
-Иргэний улсын бүртгэлийн Civilreg.client.tool, Vertiech.client.tool  программын шинэчлэлт хийж, сумын бүртгэгч-14, аймгийн улсын бүртгэгч-2, хяналтын байцаагч-1 нийт 17 компьютерт прораммыг суулгалаа.
-Шинээр томилогдсон Сайхан-Овоо сумын бүртгэгч Ц.Отгонсугирын тоног төхөөрөмжид программуудыг суулган, ажиллах бэлэн байдлыг ханган, хүлээлгэн өглөө.
-Д.Нямсүрэн хяналтын байцаагчын finger check, аймгийн 2 иргэний бүртгэгч болон 15 сумдын онлайн прораммын хурууны хээ уншигч болон гадаад паспорт хурууны хээ унших Civilreg.client.tool түүлүүдийг шинэчиллээ.
-Эд хөрөнгийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч, хэлтсийн дарга, Дэрэн сумын notebook болон суурин компьютерийг форматлаж, дотоод сүлжээнд ажиллах программуудыг суулган хүлээлгэн өгсөн.
-Гадаад паспортын олголтын программ шинэчлэгдэж аймгийн төвийн иргэний 2 бүртгэгчийн компьютерийн программыг шинэчлэн, гарын авлагын дагуу заавар зөвөлгөө өгч ажилласан.
-Хуучин зургийн программ ажиллахгүй болсон тул аймгийн төвийн иргэний 2 бүртгэгчийн компьютерт шинэчилж суулгалаа.
-Иргэний бүртгэгч Ш.Чулуунжаргал, Сайхан-Овоо сумын бүртгэгч Ц.Отгонсугир нарын принтерийн хорны чипийг сольсон.
- Хэлтсийн нэг цэгийн үйлчилгээ болон архивын өрөөнд тог баригч суурилуулав.
-Луус сумын 4g зөөврийн төхөөрөмжийн лангын утсыг шинэчлэн сольж, бусад тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган Иргэний бүртгэгч Б.Санчирмаад хүлээлгэн өглөө.
-24/7 өөртөө үйлчлэх үйлчилгээний цэгийг нээн, хаягжуулж үйл ажиллагааг тогтмол явуулах, заавар зөвлөмж иргэдэд өгөх, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.







Хэлтсийн шинээр орсон:

- Говь-Угтаал сумын бүртгэгч Б.Одончимэг

-Сайхан-Овоо сумын бүртгэгч Ц.Отгонсугир

-Цагаандэлгэр сумын бүртгэгч З.Отгонмаа нарын мэдээлэл тээгч техник, хэрэгслийн үзүүлэлтийг гарган, хувийн хэргийг хөтлөж, албан хаагчдын мэдээлэл тээгч техник, хэрэгслийн үзүүлэлтийг гарган, хувийн хэргийг хөтлөн, хавтаслалаа.




Хэлтсийн албан хаагчдын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудас болон бусад мэдээллийг вэб хуудсанд оруулж, нийт 138 мэдээ бэлтгэн 2024 оны 5-р сарын байдлаар вэб хуудасны хандалтын тоо 1664, 4.2к гишүүнтэй болжээ.

Цахим фэйсбүүк пэйж хуудсанд:

- УБЕГ-ын мэдээ- 32
- ЗДТГ-ын мэдээ- 42
- E-Mongolia мэдээ- 5
- Дундговь УБХ-ын мэдээ- 59













Хэлтсийн www.dundgovi.burtgel.gov.mn вэб сайтад текстэн мэдээ 44 видео мэдээ 11 бэлтгэн хөгжүүлэлт хийлээ.




Хэлтсийн үйлчилгээний сар бүрийн нэгтгэсэн тоон мэдээгээр 1-р сараас 5-р сарын инфографик мэдээлэл бэлтгэн сар бүрийн 28-ны дотор олон нийтэд хүргэн, вэб сайтад байршууллаа.
















### *1.8.Ээлжит сонгуулийн программ, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангаж ажиллах*

Dell i5 notebook, 4g usb dongle, futronic fs88hs хурууны хээ уншигч, камер, usb салаалагч, уртасгагч, тэжээлийн залгуур, epson принтер зэрэг тоног төхөөрөмжийг УБЕГ-ын МТГ-аас хүлээн авч юнителийн 2g, 3g сүлжээгүй Адаацаг, Эрдэнэдалай сумдад туршилт хийхээр ажиллаж байна.








УБЕГ-аас зохион байгуулсан онлайн сургалт, сумдын улсын бүртгэгч нартай хэлтсээс зохион байгуулсан сургалт, бусад байгууллагуудаас ирж сургалт зохион байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллалаа.

-УБЕГ-ын зохион байгуулсан-3

-Төрийн албаны зөвлөлийн сургалт-11

-Төрийн албан хаагчдын мэдээллийн технологи ашиглах чадавхыг хөгжүүлэх сургалт-1

-Дундговь аймгийн ЗДТГ-аас зохион байгуулж байгаа "ЦАХИМД ХЭВШЭЭ" сургалт-1

-Кибер аюулгүй байдал-1

- Зүрх ба тархи-1

-Мөрөөдөл-1 нийт 19 сургалтанд хамрагдлаа. Хэлтсийн болон сумдын албан хаагчдын компьютерт өдөр тутмын шаардагдах хэрэглээний программыг суулган, танхимын сургалт зохион байгуулсан.











Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг хангаң нууц үг, нэвтрэх нэрийг солих зэрэг ажлуудыг тухай бүрт нь түргэн шуурхай хийж гүйцэтгэн, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллалаа.Үүнд:

-Хэлтсийн албан хаагчдын тоног төхөөрөмжийн нууцлал, аюулгүй байдлыг хангаң нэвтрэх нэр, нууц үгийг I улиралд 2 удаа солин, тоног төхөөрөмжийн нууцлалыг хангаж ажиллалаа.

-Хэлтсийн www.mail.gov.mn хаягын I улирлын нууц үгийг 2 удаа солилоо.

-Сайхан-Овоо, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын бүртгэгч нарт erp.e-mongolia.mn, edoc.mojha.gov.mn нэгдсэн систщмийн нэвтрэх эрх олгон нууц кодыг шинээр үүсгэж, тэтгэвэрт гарсан 2 албан хаагчдын нэвтрэх эрхийг хаалгалаа.

-Ахлах нягтлан бодогч Х.Гарамын mail.gov.mn хаягын нэвтрэх нууц үгийг сэргээж сольж өглөө.



Байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааг авч хэрэглэгчийн үнэлгээнд дүн шинжилгээ хийн байгууллагын хамт олонд Toxic харилцаа хандлагын сургалт орлоо.












Хэлтсийн хэмжээнд нэг цэгийн үйлчилгээ, архив, 2 давхрын серверийн өрөөнүүдэд тус бүр тог баригч, хяналтын камер суурилуулсан.



Вэб болон фэйсбүүк, пэйж хуудсанд Дэлгэрцогт сумын сул орон тооны зарыг байршуулсан.







Вэб хуудсанд албан хаагчийн ёс зүйн дүрмийг шинэчилж оруулсан.






***6.6. Хэлтсийн спорт, урлаг, эрүүл мэндийн ажлын хэсгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах.***

- УБЕГ-ын “БҮРТГЭЛИЙН АЖИЛТНЫ БАЯР – 2023” СПОРТЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН байгуулагдаж Шилдгийн шилдгээр “ТӨВИЙН БҮС” буюу Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгуудын албан хаагчдаас бүрдсэн баг тамирчтд нийлбэр дүнгээр манлайлан Шилдгийн шилдгээр “ТӨВИЙН БҮС” буюу Дархан-Уул, Дундговь, Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгуудын албан хаагчдаас бүрдсэн баг тамирчид багийн нийлбэр дүнгээр бусдыгаа манлайлан ШИЛЖИН ЯВАХ ЦОМ-ын эзнээр шалгарсан.
- Агентлагуудын дунд зохион байгуулсан гар бөмбөгийн тэмцээнд орж III байр эзэлж, баг хамт олноороо VI байр эзэллээ.

-“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”, “ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 101 ЖИЛ”-ИЙН ойн баярыг угтаж, Дундговь аймгийн тусгай чиг үүрэгтэй байгууллагын дунд зохиогдсон “ГАР БӨМБӨГ”-ийн төрөлд IV байр эзэллээ.






Үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр цахим хуудсанд 4 удаа шинэчлэн байршууллаа.



***7.2. Үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт байршуулах***

-Төлбөр, хураамжийн үнэ, тарифын тоо, үйлчлүүлэгчээс авч буй төлбөр, хураамжийн үнэ, тарифын талаарх мэдээллийг хууль эрх зүйн үндэслэл журмын хамт нэг цэгийн үйлчилгээний танхим болон вэб хуудсанд байршууллаа.



***Шинэлэг ажил зохион байгуулах:***

-Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс зохион байгуулсан “10 минутын дадал”-ыг ажлын 5 өдөр дасгал хөдөлгөөн хийж хэвшүүлж байна.



-"Гэр бүл, хүүхэд хөгжил хамгааллын жил", "Дэлхийн усны өдөр", "Цэнхэр тууз аян"-ын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын газрын "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл"-өөс зохион байгуулсан "Үнэт баялаг-Ус" рийлс бичлэгийн уралдаанд амжилттай оролцон 3-р байр эзлэж 100.000 төгрөгийн “Номгон” дэлгүүрээр үйлчлүүлэх эрхээр шагнагдлаа.

Erp.e-mongolia.mn , edoc.mojha.gov.mn албан хэрэг хөтлөлтийн программын ашиглалтыг үйл ажиллагаандаа хэрэглэж байна.



Үндэсний Монгол хэл бичгийг сурах, сургах түгээн дэлгэрүүлэх, сурч эзэмших, Монголд бичгийг сэргээн хэрэглэх төрийн бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэх “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Төрийн албан хаагчдын “Үндэсний бичгийн цахим бичвэр”-ийн уралдаанд амжилттай оролцож компьютер дээр шивж сурч байна.




| № | Уралдаан, сорилын нэр | Арга хэмжээний төрөл, оролцогчид | Уралдаанд оролцох төрөл, ангилал | Зохион байгуулах он, сар, өдөр, цаг | Уралдааныг хариуцан зохион байгуулах байгууллага, утасны дугаар | Уралдаан зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Төрийн албан хаагчдын "Үндэсний бичгийн мэдлэг сорих сорил" арга хэмжээ | Төрийн албан хаагчид, ЕБС-ийн багш нар, бага анги, цэцэрлэгийн багш нар | Төрийн албан хаагчид / ЕБС-ийн багш нар / Бага анги, цэцэрлэгийн багш нар | 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 15-18 цаг | Сайнцагаан сумын Эрдмийн далай сургууль /86201693, 96163496/ | Сайнцагаан сумын Эрдмийн далай сургуулийн хичээлийн байр |
| 2 | Төрийн албан хаагчдын "Үндэсний бичгийн цахим бичвэр"-ийн уралдаан | Төрийн албан хаагчид, удирдах ажилтнууд, иргэд | Төрийн албан хаагчид / Удирдах ажилтнууд / Иргэд | 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 14.00-15.00 цаг | Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургууль /88126383, 89987298/ | Сайнцагаан сумын Хүмүүнлэг сургуулийн хичээлийн байр /Политехникийн коллеж/ |
| 3 | ЕБС-ийн 7-12-р ангийн суралцагчдын дунд үндэсний бичгээр бичих "Уран бичлэг"-ийн уралдаан | ЕБС-ийн 7-8-р анги, 9-10-р анги, 11-12-р ангийн суралцагчид | ЕБС-ийн 7-8-р анги / ЕБС-ийн 9-10-р анги / ЕБС-ийн 11-12-р ангийн суралцагчид | 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 14.00-16.00 цаг | Сайнцагаан сумын Цэцэг билиг сургууль /99338957/ | Сайнцагаан сумын Цэцэг билиг сургуулийн байр |
| 4 | Иргэдийн дунд зохион байгуулах үндэсний бичгийн "Тээгч, түгээгч" өдөрлөг арга хэмжээний "Уран үзэгтэн", "Алтан хонх", "Минутын уншлага" уралдаан | 15 сумыг нийлбэр дүнгээр байр эзлүүлэх | "Уран үзэгтэн" / "Алтан хонх" / "Минутын уншлага" | 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 15-18 цаг | Аймгийн Политехникийн коллеж /99292663, 91460610/ | Аймгийн Политехникийн коллежийн байр |
| 5 | Аймгийн хэмжээнд "Үндэсний бичиг үсэг-2024" арга хэмжээг тэмдэглэх, шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаа | Уралдаанд байр эзэлсэн сумд, иргэд, төрийн албан хаагчид, хүүхдүүдэд шагнал гардуулах | 5 төрөл тус бүрт 1-3 байр эзэлсэн сумд, иргэд, төрийн албан хаагч, суралцагчид | 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 15.00-17.00 цаг | Аймгийн ЗДТГ-ын Сулд танхим /99067149/ | Аймгийн ЗДТГ-ын Сулд танхим |

Coreldraw программыг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.

## 4-РТ ДОТООДЫН ХЯНАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, улсын бүртгэл болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж алдаа, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх зориллгоор хяналтын улсын байцаагчийн 2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөө батлуулан иргэн, ЭХЭУБ, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн нийт 1758 бүртгэлд хяналт шалгалт хийгээд байна. Иргэний улсын бүртгэлийн 687, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 1044, хуулийн этгээдийн 22, архивын чиглэлээр 5 бүртгэлд хяналт, шалгалт хийснээс нийт 196 алдаа зөрчил илэрсэн бөгөөд тухай бүр улсын бүртгэгчидээр засах боломжтойг засуулж, зөрчлийн тэмдэглэл үйлдэж, дүгнэлт гаргах шаардлагатай бүртгэлд дүгнэлт гаргаж ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ЭХЭУБ-ийн тасгийн дарга Л.Мөнхсарнайгийн бүртгэлд хяналт шалгалт хийснээс 41 бүртгэлд зөрчил илэрч зөрчлийн тэмдэглэл ирүүлсэн. Мөн 2024 оны 02 дугаар сарын 23-ын өдрийн 17 тоот албан шаардлага тус тус ирүүлсэн бөгөөд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр засах 8 бүртгэлд дүгнэлт гаргаж засварлалаа.

Хяналт шалгалтын газраас ирүүлсэн албан шаардлагын хүрээнд тус хэлтсийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч О.Ганцэцэг, Н.Уугантуяа нарын 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 02 дугаар сарыг дуустлах бүх бүртгэлд хяналт шалгалт хийж, зөрчлийн тэмдэглэлийг Хяналт шалгалтын газарт хүргүүлээд байна.

Хяналт, шалгалтын газраас Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч Б.Сайхантуяагийн үйл ажиллагааг хянасан бөгөөд 65 бүртгэлд зөрчил илэрсэн үүнээс хуулийн хугацаанд баталгаажаагүй гэх зөрчлөөс бусад зөрчил байцаагчийн дүгнэлтээр засварлагдсан. Зөрчлийг сумд, улсын бүртгэгч нараар харуулбал.




Илэрсэн зөрчил




Тайлант хугацаанд 25 дүгнэлт үйлдсэнээс эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 11, иргэний улсын бүртгэлийн 12 , хуулийн этгээдийн 2 байна.

Зөрчлийн тухай хуулийн 15.24 дүгээр зүйл. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих буюу 15.24.1, 15.24.2, 15.24.4-т заасныар иргэд ихэвчлэн торгууль төлж байгаа бөгөөд олон нийт иргэдэд зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор видео шторк явуулах, facebook хуудсаар мэдээлэл түгээх зэрэг ажлуудыг хийлээ. Мөн түүнчлэн 15 сумдын улсын бүртгэгч нараас тухайн онд 16, 25, 45 насанд хүрч иргэний үнэмлэх захиалах иргэдийн судалгааг авч, иргэн бүртэй утсаар холбогдож төрсөн өдрөөс хойш 30 хоногийн дотор иргэний үнэмлэхийн сунгалтаа хийлгэх ёстойг сануулж ажиллаж байна. Уг ажлыг хийснээр зөрчлийн тухай хуулиар торгуулах иргэдийн тоо буурч байгаа давуу талтай юм.

Дундговь аймгийн хэмжээний Ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагчид болон польтехникийн коллежийн нийт 60 сурагч, оюутнуудад Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, зөрчлийн тухай хуулийн сургалт зохион байгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулахаар Дундговь аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ажиллахаар удирдамж боловсруулж, төсөв батлуулахаар хүргүүлээд байна.

Хагас жилийн байдлаар 34 иргэнд зөрчлийн тухай хууль, зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу торгуулийн арга хэмжээ аваад байна. Энэ нь 2023 оны мөн үеийнхтэй харьцуулахад буурсан үзүүлэлттэй байна.

Бүртгэлийн хяналт, шалгалт хийх явцад шилжилт хөдөлгөөний бүртгэл, үрчилсний бүртгэл, төрсний бүртгэлийг хийх явцад бүртгэгчид бусад бүртгэлээс илүүтэйгээр алдаа гаргадаг болох нь тогтоогдсон. Иймд дээрх бүртгэлүүдийг хийхдээ алдаа гаргахгүй байх үүднээс урьдчилан сэргийлж 2 удаагийн цахим сургалт зохион байгууллаа.



2024оны 01 дүгээр сарын 29-ны өдөр “Шилжилт хөдөлгөөний” бүртгэлийн талаар чиглэл өгөх сургалт

2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр “Үрчлэлт” түүний эрх зүйн үр дагавар

Сургалт зохион байгуулан өдрөөс хойш тухайн бүртгэлүүдэд нэг бүрчлэн өдөр тутамд хяналт шалгалт хийсэн бөгөөд үр дүн өгч алдааны тоо буурсан.

Хяналт шалгалтын газраас ирүүлсэн 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 6/4865 дугаартай үүрэг, даалгавар хүргүүлэх тухай албан бичигийн хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 15-ний өдрийг дуустлах хугацааны шилжилт хөдөлгөөний 15 сумын 236 бүртгэлд хяналт шалгалт хийж илтгэх хуудасыг хүргүүлсэн. 2024 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 6/5641 дугаартай чиглэл хүргүүлэх тухай албан бичигийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 26-ний өдрийг дуустлах хугацааны шилжилт хөдөлгөөний 15 сумын 174 бүртгэлийн нотлох баримт, цахим сан, журнал бүртгэлд хяналт шалгалт хийж, чиглэлийн 1 дэх хэсэгт заасны дагуу тус хугацаанд бүртгэсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг ИУБ-22 маягт, бүртгэлийн дэвтэртэй нэг бүрчлэн тулгаж, хаасан тухай тэмдэглэгээг бүртгэлийн дэвтэрт хийж, ИУБ-22 маягтын үлдэгдлийг бүртгэн акт үйлдэж, лацдах үйл ажиллагааг явууллаа.

174 бүртгэл шилжилт хөдөлгөөний бүртгэлийг зогсоосон хугацаанаас өмнө иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэж, баталгаажуулсан байна.





Шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа 2 хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, хэрэг маргааны судалгааг холбогдох газарт хүргүүллээ.

-С.Дэжидийн нэхэмжлэлтэй Улсын бүртгэлийн хэлтэст холбогдох улсын бүртгэлийн Ү-0814000325 дугаарт бүртгэлтэй “Ундрам мандал” ХХК-ийн Дундговь аймгийн 7-р багийн нутаг дэвсгэрт байрлах 493,64 мкв талбайтай үйлчилгээний зориулалттай үл хөдлөх эд хөрөнгийн маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр 3 удаагийн шүүх хуралд оролцож

Дундговь аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2023.04.12-ны өдрийн 11/Ш32023/0048 дугаарын хэрэг хянан шийдвэхлэх ажиллагааг түдгэлзүүлсэн тухай захирамж гарч түдгэлзүүлсэн бөгөөд тус хэргийг дахин сэргээж шүүх хуралдаан болж 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 117/Ш32024/0017 дугаартай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж гарсан. Гэвч Нэхэмжлэгч С.Дэжид давж заалдах шатанд гомдол гаргаж 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 221/ШТ2024/330 дугаартай Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол гарч нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай шүүгчийн захиамжийн тухай тогтоол гарч уг маргаан үргэлжилж байна.

-2024 оны 03 дугаар сарын 15-ны нэхэмжлэгч Б.Ганчимэгийн нэхэмжлэлэтэй өмчлөлгч болохыг тогтоолгож, улсын бүртгэлд өмчлөгчөөр бүртгүүлэхийг даалгуулах гомдолд хариуцагчаар оролцож нэхэмэлэлийг хүлээн авч, хариу тайлрыг хүргүүлээд байна.

## ***5-РТ. БИЧИГ ХЭРЭГ, АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:***

Бичиг хэргийн дотоод үйл ажиллагаанд цахим сүлжээг бүрэн нэвтрүүлэх, ашиглах зорилгоор албан бичиг цахимаар солилцон, өргөдөл гомдлыг веб сайт, мэйл, фэйсбүүк групп, хуудсаар хүлээн авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. Цаасаар ирсэн өргөдөл гомдлыг албан бичиг хөтлөлтийн EDOC системрүү бүртгэн холбогдох албан тушаалтанд цохсоноор тухайн албан хаагч цаг алдалгүй өөрт ирсэн бичгийг шийдвэрлэж байна.

2024 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар нийт 328 албан бичиг ирснээс 325 бичгийг хугацаанд нь шийдвэрлэж 3 бичгийг судлаж байна. 255 албан бичиг явуулсан бөгөөд хариутай 112 бичиг байна. Бичгийн барагдуулалт 100% байна.







Байгууллага

ИРСЭН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс

/2024.01.01-2024.05.20/

2024 оны 05 дугаар сарын 20 10:58

| Д/д | Хэлтсийн нэр | Энэ хугацаанд ирсэн бичгийн тоо(A=A1+A2+A3; | Бүртгэгдсэн байдал: Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо | Бүртгэгдсэн байдал: Системээр бүртгэгдсэн бичгийн тоо | Хуваарилалт: Хуваарилагдсан бичгийн тоо | Хуваарилалт: Хуваарилагдаагүй бичгийн тоо | Үүнээс хариутай бичгийн тоо B=B1+B2+B4 | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаандаа шийдвэрлэсэн | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа хэтэрсэн: Шийдвэрлэсэн | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа хэтэрсэн: Шийдвэрлэээгүй | Шийдвэрлэлтийн байдал: Судалж байгаа | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа дөхсөн | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа сунгуулсан | Шийдвэрлэлтийн байдал: Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь | Үүнээс хариугүй бичгийн тоо C=C1+C2+C4 | Хаалтын байдал: Хугацаандаа хаасан | Хаалтын байдал: Хугацаа хэтэрсэн: Хаасан | Хаалтын байдал: Хугацаа хэтэрсэн: Хаагаагүй | Хаалтын байдал: Судалж байгаа | Хаалтын байдал: Хариугүй бичгийн хаалтын хувь | Нийт ирсэн бичгийн шийдвэрлэлтийн хувь | Шийдвэрлэлтийн дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | A1 | A2 | A3 | A4 | B | B1 | B2 | B3 | B4 | B5 | B6 | B7 | C | C1 | C2 | C3 | C4 | C5 | D | AT |
| 1 | 2 | 3 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 | 16 | 17 | 18 | 19 | 20 | 21 | 22 | 23 | 24 |
| 1 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг | 6 | 2 | 4 | 6 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.00 | 6 | 5 | 0 | 0 | 1 | 100.00 | 100.00 | 3.00 |
| 2 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг | 25 | 11 | 14 | 25 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 100.00 | 25 | 24 | 0 | 0 | 1 | 100.00 | 100.00 | 3.44 |
| 3 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс | 297 | 100 | 197 | 297 | 0 | 112 | 111 | 0 | 0 | 1 | 0 | 4 | 100.00 | 185 | 182 | 0 | 0 | 3 | 100.00 | 100.00 | 3.91 |
| Нийт | | 328 | 113 | 215 | 328 | 0 | 112 | 111 | 0 | 0 | 1 | 0 | 4 | 100.00 | 216 | 211 | 0 | 0 | 5 | 100.00 | 100.00 | 3.85 |

## ЯВУУЛСАН БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

/2024.01.01-2024.05.20/

2024 оны 05 дугаар сарын 20 10:19 Улаанбаатар хот

| Д/д | Явуулсан байгууллага | Нийт | Хариутай | Хариугүй | Хугацаанд нь хариу ирүүлсэн | Хугацаа хэтр үүлж хариу ирүүлсэн | Шийдвэрлэх шатандаа | Хугацаа хэтэрсэн, хариу ирээгүй | Шийдвэрлэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төрийн байгууллага | | | | | | | | | |
| Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс | | | | | | | | | |
| 1 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс | 250 | 1 | 249 | 0 | 0 | 1 | 0 | 100 % |
| | **Хэлтсийн нийт** | **250** | **1** | **249** | **0** | **0** | **1** | **0** | **100 %** |
| | **Байгууллагын нийт** | **250** | **1** | **249** | **0** | **0** | **1** | **0** | **100 %** |
| | **Нийт:** | **250** | **1** | **249** | **0** | **0** | **1** | **0** | **100 %** |

## ХАРИУТАЙ БИЧГИЙН ШИЙДВЭРЛЭЛТИЙН МЭДЭЭ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын харьяа Дундговь аймаг дахь улсын бүртгэлийн хэлтэс

/2024.01.01-2024.05.20/

2024 оны 05 дугаар сарын 20 10:08

| Д/д | Байгууллагын нэр | Энэ хугацаанд ирсэн хариутай бичгийн тоо (A=A1+A2+A3; A=B1+B2; A=C1+C2+C4) | Бүртгэгдсэн байдал: Байгууллагаар бүртгэгдсэн бичгийн тоо | Бүртгэгдсэн байдал: Системээр бүртгэгдсэн бичгийн тоо | Хуваарилалт: Хуваарилагдсан бичгийн тоо | Хуваарилалт: Хуваарилагдаагүй бичгийн тоо | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаандаа шийдвэрлэсэн | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа хэтэрсэн: Шийдвэрлэсэн | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа хэтэрсэн: Шийдвэрлээгүй | Шийдвэрлэлтийн байдал: Судалж байгаа | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа дөхсөн | Шийдвэрлэлтийн байдал: Хугацаа сунгуулсан | Зөрчил тооцогдсон албан бичгийн тоо | Тооцогдсон зөрчлийн тоо | Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | A | A2 | A3 | B1 | B2 | C1 | C2 | C3 | C4 | C5 | C6 | D | D1 | E |
| **1** | **2** | **3** | **5** | **6** | **7** | **8** | **9** | **10** | **11** | **12** | **13** | **14** | **15** | **16** | **17** |
| 1 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс | 112 | 46 | 66 | 112 | 0 | 111 | 0 | 0 | 1 | 0 | 4 | 7 | 4 | 100.00 |
| **Нийт** | | **112** | **46** | **66** | **112** | **0** | **111** | **0** | **0** | **1** | **0** | **4** | **7** | **4** | **100.00** |

***Тайлбар:*** *"Хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээ" тайлангаар Хайлтын нөхцөлд сонгосон "Эхлэх огноо", "Дуусах огноо"-ны хооронд бүртгэсэн нийт хариутай бичгийн шийдвэрлэлтийн мэдээг харуулна. Бичиг хэрэг хариуцсан ажилтан тайланг сар бүрийн эхний 14 хоногт, сарын сүүлд, улиралд, хагас жилд, жилд тус тус гаргаж удирдлагад танилцуулж шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллана.*

A - **Нийт ирсэн хариутай бичгийн тоо: Сонгогдсон хайлтын хугацаанд ("Эхлэх огноо", "Дуусах огноо"-ны хооронд бүртгэгдэж) ирсэн нийт хариутай бичгийн тоо**
C5 - **Хугацаа дөхсөн: Хугацаа дуусах дөхсөн албан бичгийн тоо**
D - **Зөрчил тооцогдсон албан бичгийн тоо: Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн нийт бичгээс зөрчил тооцогдсон бичгийн тоо**
D1 - **Тооцогдсон зөрчлийн тоо: Тайлангийн хугацаанд бүртгэгдсэн нийт бичигт тооцогдсон зөрчлийн тоо**
E - **Хариутай бичгийн шийдвэрлэлтийн хувь: E = (C1+(C2*0.5)) * 100 / (A - C4+C3)**

Хэлтсийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт тайлан мэдээг хуулийн хугацаанд гарган хүргүүлэх ажлын хүрээнд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч, хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж, өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд тавих дотоодын хяналтыг сайжруулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

| **Агуулга** | | **Тоо** | **Хувь** |
|---|---|---|---|
| Өргөдөл, гомдлын төрөл | Иргэний улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаа холбоотой | 16 | 72% |
| | Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой | 4 | 18% |
| | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой | 1 | 5% |
| | Улсын бүртгэлийн нэгдсэн архив | 1 | 5% |
| 2024 оны эхний хагас жилд ирсэн нийт хүсэлтийн тоо | | 22 | |




| Агуулга | | Тоо | Хувь |
|---|---|---|---|
| Хүлээн авсан хэлбэр | Биеэр | 22 | 100% |
| Шийдвэрлэж хариу өгсөн байдал | Албан бичгээр | 2 | 9% |
| | Утсаар | 19 | 90% |

Хэлтсийн өргөдөл, гомдлыг хүлээн авсан хэлбэр:

| Д/д | Өргөдөл гомдол хүлээн авсан хэлбэр | Эхний хагас жилд | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Иргэн өөрийн биеэр ирж өргөдөл өгсөн | 22 | 100% |
| 2 | Байгууллагын тусгай дугаараар /7059-3096/ | 0 | 0% |
| 3 | Байгууллагын вэб сайт, мэйл, сошиал хуудсаар | 0 | 0% |
| 4 | Дундговь аймгийн санал хүсэлт авах утсаар /7059-106/ | 0 | 0% |
| 5 | ААНБ, хуулийн этгээдээс ирүүлсэн | 0 | 0% |
| Нийт | | 22 | 100% |

Иргэдийг чирэгдүүлэхгүй байх үүднээс өргөдөл, гомдлын хүлээн авах шат дараалллыг бууруулж Архив, бичиг хэргийн ажилтан холбогдох хууль журмын дагуу шууд хүлээн авч, удирдлагад танилцуулан, цохуулж холбогдох албан тушаалтанд өгч шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна. 70593096 дугаартай утсаар иргэдээс иргэний улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой мэдээллийг авч, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй иргэд бичгээр хүсэлтээ гаргаж, шийдвэрлүүлж байна. Мөн байгууллагын сайт, цахим хуудсаар гомдол, санал, талархал хүлээн авч байна.

Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн хөрвүүлэлтээс иргэдийн мэдээлэл алдаатай, орхигдсон учраас нас барсны бүртгэл, гэрлэлтийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлгүй тухай, шилжилт хөдөлгөөн, төрөлтийн бүртгэлд эцэг эхийн мэдээлэл ороогүй зэрэг зөрчилтэй холбоотой нийт 20 хүсэлт ирснийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний улсын бүртгэлийн газарт холбогдох материалыг хүргүүлснээр мэдээллийн санд иргэдийн мэдээллийг засвар болон нэмэлт өөрчлөлтийн бүртгэлээр залруулж оруулсан. Нотлох баримт нь бүрдсэн тохиолдолд хүсэлтийг 1 хоногт нь шийдвэрлэж байна.

Хяналтын улсын байцаагчид хандаж төрөлтийн мэдээлэл мэдээллийн санд оруулах хүсэлтийг хүлээн авч холбогдох нотлох баримтын бүрдүүлэлт хийхэд нэлээд хугацаа шаардагдаж, улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн УБЕГ-ын Хяналт

шалгалтын газарт хүргэгдэн мэдээллийн санд засвар өөрчлөлт оруулан ажиллаж байна.

**Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн мэдээ**

2024 оны 05 дугаар сарын 20 10:19 Улаанбаатар хот

| Д/д | Хэлтэс нэгж | Нийт тоо | Төрөл | | | | | Хаанаас | | | Шийдвэрлэсэн | | Шийдвэрлэж байгаа | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Талархал | Санал | Хүсэлт | Гомдол | Мэдээлэл | Иргэнээс | Ажилтанаас | Байгууллагаас | Хугацаандаа | Хугацаа хэтэрсэн | Хугацаа болоогүй | Хугацаа хэтэрсэн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 | 15 |
| 1 | | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| 2 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасаг | 14 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 14 | 0 | 0 | 14 | 0 | 0 | 0 |
| 3 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасаг | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |
| 4 | Дундговь аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс | 6 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 6 | 0 | 0 | 5 | 0 | 1 | 0 |
| | Нийт | 22 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 22 | 0 | 0 | 21 | 0 | 1 | 0 |

Аймгийн хэлний бодлогын салбар зөвлөлөөс ”Үндэсний бичиг үсгийн баяр-2024”-ыг угтан зохион байгуулж буй арга хэмжээний мэдлэг сорих сорилд Хэлсийн дарга, цахим бичвэрийн уралдаанд мэдээлэл технологийн ажилтан болон нярав оролцсон. Мөн хэлтсийн албан хаагчид үндэсний бичигт цахимаар суралцаж байна. Хэлтсийн өрөө тасалгаа, зар мэдээллийн брошур, хавтас зэргийг үндэсний бичгээр боловсруулан ажиллаж байна.








Мөн аймгийн төрийн архивт шилжүүлэх 2013-2016 оны байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 02 дугаар данс үйлдэн төрийн архивын нэгдсэн системд 13 баримтыг шивж оруулан шинээр хавтаслан хаягжуулж аймгийн төрийн архивт цаасан болон цахим хэлбэрээр шилжүүлэв. 70 жил хадгалах болон, түр хадгалах хадгаламжийн нэгжийн 2016 он хүртлэх баримтыг архивын тасгийн дэргэдэх баримт нягтлан шалгах аргазүйн комиссоор батлуулан ажиллалаа.




## 6-РТ ТӨСӨВ САНХҮҮГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Тус хэлтсийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Си Пи Ти Эй аудитын компани 2024 оны 2 дугаар сард аудит хийж санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан.

Тус хэлтэс нь нэмэлт санхүүжилтээр УБЕГ-ын Даргын 2024 оны 02-р сарын 15 өдрийн А/24 тоот тушаалаар батлагдсан Монгол Улсын Их Хурлын 2024 оны сонгууль зохион байгуулах зардалд 18,756.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй байна. Мөн орон нутгаас 10,284.4 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр хүлээн авч төрийн захиргааны албан хаагчдын 2024 оны 1-р улирлын орон нутгийн нэмэгдэлд 1 албан хаагчийн үндсэн цалингийн 30 хувиар тооцож олгосныг ТЗ-ны 22 ажилтанд 5-р сарын цалин дээр бодож олгосон.

2024 оны 05 сарын 01–ны байдлаар байгууллагын 9 ахмадад 2024 оны сар шинийн баяраар тус бүр 133.2 мянга, нийт 1198.8 мянган төгрөгийн гарын бэлэг, мөн 5-р сард өндөр настан Ш. Нарангэрэлд өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулж 2,500.0 мянган төгрөгийн нэг удаагийн дэмжлэг, нийт 3,698.5 мянган төгрөгийг ахмадын сангаас зарцуулсан.

2024 оны 1-р улирлын санхүүгийн тайланг УБЕГ-ын СААХ-т Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу 4 сарын 15-нд хуулийн хугацаанд хүргэгдэж нэгтгэгдсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын программд 2023 оны жилийн эцсийн өмчийн мэдээ, захиргааны статистик маягтыг 3-р сард оруулж хугацаанд нь 100 хувь тооцуулан ажилласан.

Хэлтсийн Даргын 2023 оны 12-р сарын 13-ны өдрийн А/27 тоот тушаалаар жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор илэрсэн цаашид ашиглах боломжгүй 20 нэр төрлийн 17,210.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг, актлах саналыг хүргүүлэн, хагас жилийн санхүүгийн тайланд үр дүнг тусгахаар ажиллаж байна.

Батлагдсан төсвөөс 05-ð сарын 01-ны байдлаар 314,301.5 мянган төгрөгийн санхүүжилт авч цалин хөлсний зардалд 233,069.5 мянга, унаа хоолны зардалд 26,500.0 мянга, НДШ-д 32,947.8 мянга, бичиг хэргийн зардалд 521.0 мянга, тээвэр шатахуунд 461.9 мянга, шуудан холбоонд 342.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 1,442.1 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлийн зардалд 560.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 300.0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 100,0 мянга, урсгал засвар 99.0 мянга, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл 25.0 нийт 296,369.4 мянган төгрөг зарцуулж, 17,932.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй төсвийн гүйцэтгэл 94.3% байна.

Төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /мянган төгрөг/ хүснэгт.




УБЕГ-аас тус хэлтсийн 2024 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 80,000.0 мянган төгрөгөөр баталсан. 05-ð сарын 01 өдрийн байдлаар орлогын төлөвлөгөөгөөр 26,666.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээс, 25,426.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, орлогын төлөвлөгөөний биелэлт 95.3 хувьтай байна. Үүнээс 24,312.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 1,113.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр төрлөөр нь диаграммаар харуулбал: диаграмм. /мянган төгрөг/




Төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон үйлчилгээний орлогын 1-р сараас 4-р сарын мэдээг тус бүр 4 удаа УБЕГ-т хүргүүлсэн. Нийгмийн даатгалын шимтгэлийн 1-р сараас 4-р сарын тайланг сар бүр нийт 4 удаа, 2023 оны 4-р улирал, 2024 оны 1-р улирлын татварын тайланг цахимаар тоон гарын үсгээр баталгаажуулан улирал бүр гаргаж харьяа байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн.

Шилэн дансны тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу 2024 оны 01 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01 өдөр хүртэлх хугацаанд 56 мэдээллийг 100 хувь байршуулсан. Үүнээс мэдээллээгүй мэдээлэл 0, хугацаа хоцорсон төлөвтэй мэдээлэл 0, хугацаандаа байршуулсан 56 мэдээлэлтэй, 100 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

2024 оны 4-р сард ХЗДХЯ, Эрин системс ХХК, УБЕГ-ын СААХ-ээс зохион байгуулсан E-Accounting шинэ санхүүгийн программын сургалт болон ММНБИ-ийн 2024 оны тасралтгүй боловсролын төвийн бүсийн сургалтад 5-р сарын 3-аас 4-ны өдрүүдэд тус тус хамрагдсан. Тус бүсийн сургалтад Архангай, Өвөрхангай, Төв аймаг, Баянхонгор, Өмнөговь, Дундговь нийт 6 аймгийн 120 гаруй мэргэшсэн нягтлан бодогчид оролцож, мэргэжлийн ур чадварын тэмцээнд багаараа 1-р байр эзэлж амжилттай оролцсон.

Тус хэлтэс нь 2024 оны 05 дугаар сарын 20-ны байдлаар өр төлбөргүй ажиллаж байна.

**7-р Сургалт, хамтын ажиллагааны хүрээнд**

- Аймгийн ХХААГазартай хамтран ажиллаж иргэдэд хоршооны талаарх мэдээллийг хүргэн Өмнөговь аймагт болсон бүсийн сургалт зөвөлгөөнд 2 албан хаагч хамрагдлаа.
- Дундговь аймгийн хэмээний Ерөнхий боловсролын сургуулиудын 10-12 дугаар ангийн сурагчид болон польтехникийн коллежийн нийт 60 сурагч, оюутнуудад Улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийг сурталчлах, зөрчлийн тухай хуулийн сургалт зохион байгуулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт зохион байгуулахаар Дундговь аймгийн ИТХ-ын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран ажиллахаар болж удирдамж, төсөв, хөтөлбөрөө хүргүүлсэн.
- Аймгийн төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж гар утаснаасаа болон цахим орчинд бүртгэлийн үйлчилгээг авах тухай заавар зөвлөмжийг 15 сумын иргэдэд танхимаар өгч нийт 1200 иргэнийг хамруулан нягт хамтран ажиллаж байна. Үүний үр дүнд цахим орчинд бүртгэлийн үйлчилгээ авах иргэдийн тоо өмнөх оны мөн үеэс эрс өссөн үзүүлэлттэй байна.

1. Аймгийн Засаг даргад хүсэлт хүргүүлж тус хэлтсийн албан хэрэгцээнд 20,0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн санхүүжилтийг аймгийн ИТХурын шийдвэрээр батлуулж худалдан авах ажиллагаа хийгдэж байна.
2. Хулд сумын ИТХурлын шийдвэрээр ДӨТ машин, бүртгэгчийн тоног төхөөрөмж шинэчлэх 28,0 сая төгрөгийн санхүүжилтийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шийдвэрлүүлж худалдан авах ажиллагаа хийгдэж байна.
3. Баянжаргалан сумын ИТХ-ын шийдвэрээр ДӨТ машин, бүртгэгчийн тоног төхөөрөмж 25,0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлүүлэн шууд худалдан авалтын гэрээгээр татан авч ашиглалтад оруулլаа.
4. Дэрэн сумын бүртгэгчийн суурин компьютерийг ЗДТГ-ын санхүүжилтээр шийдвэрлэв.
5. Өндөршил, Цагаандэлгэр, Говь-Угтаал сумдын бүртгэгч нарт төлбөрийн пос машиныг ЗДТГ-ын санхүүжилтээр шийдвэрлүүлэв.

**6.** Улаанбаатар эрдэм их сургуультай 2 дахь удаагийн хамтран ажиллах гэрээ байгуулж тус аймагт эрх зүйн эчнээ ангийг хичээллүүлж байна. Төлбөрийн уян хатан нөхцөлтэйгөөр 1 сумын бүртгэгч суралцаж байна. Үндэсний техникийн Их сургуулийн эрх зүйн эчнээ ангийг 2 бүртгэгч 2,5 жилээр суралцаж төгсөөд байна

**ТАЙЛАН НЭГТГЭСЭН ХЭЛТСИЙН ДАРГА Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ**